



ДОРНОГОВЬ АЙМАГ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 2/40

Сайншанд сум

Журмуудыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам" Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг 4 дүгээр хавсралт, "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам", "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам" Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Биеийн тамир, спортын газрын "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг нэгдүгээр, "Төрийн албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журмуудыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүний нөөц, дотоод хяналт хариуцсан ажилтан (Э.Оюунсүрэн)-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Биеийн, тамир спортын газрын даргын 2023 оны 09 дүгээр 01-ний өдрийн А/52 дугаартай тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Биеийн тамир, спортын газрын даргын
2024 оны 06 дүгээр сарын 24-ний өдрийн
Ардугаартай тушаалын нэгдүгээр хавсралт



**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ХААГЧДАД УР
ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий түгээмэл мэргэжлийн үйлчилгээний албан хаагч /нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтан, архив бичиг хэрэг, нярав, жолооч, мужаан, слесарь, цахилгаанчин, үйлчлэгч, жижүүр болон тэдгээртэй адилтгах ажилтнууд/-ад ур чадварын нэмэгдэл олгоход Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам" болон энэхүү журмыг баримтална.

№	Албан тушаал	Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Авбал зохих оноо
1.	Төрийн үйлчилгээний албан хаагч	Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилт	30
2.		Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт	30
3.		Ажилтны сахилга, ёс зүй, харилцаа хандлага	20
4.		Ажлын цаг ашиглалт, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцоо	10
5.		Удирдлагаас өгсөн үүргийн биелэлт	10
Нийт үнэлгээ			100

Хоёр. Ур чадварын үнэлгээ:

2.1. Сарын үнэлгээгээр 85-100 буюу "Маш сайн" дүгнэгдсэн бол 20-25%, 70-85 хүртэлх оноо буюу "Хэвийн" үнэлэгдсэн бол 10-20 хүртэл хувиар үндсэн цалингаас ур чадварын нэмэгдлийг тооцож олгоно.

Гурав. Ур чадварын нэмэгдлийг дараах тохиолдолд олгохгүй.

3.1. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 70 хүртэл онооноос доош хувьтай.

3.2. Сахилгын шийтгэл хүлээсэн эсхүл сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол.

Биеийн тамир, спортын газрын даргын
2024 оны 2 дугаар сарын 23-ний өдрийн
240 дугаартай тушаалын хоёрдугаар хэвсрэлт



ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД УЛИРЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Байгууллагын төрийн албан хаагчдад Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т заасан мөнгөн урамшуулал олгоход Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам" болон энэхүү журмыг баримтална.

Хоёр. Ажлын үр дүнг үнэлэх:

2.1. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлт:

2.1.1. Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилт

2.1.2. Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт

2.1.3. Төрийн захиргааны албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

2.1.4. Ажилтны сахилга, ёс зүй, харилцаа хандлага, удирдлагаас өгсөн үүргийн биелэлт

2.1.5. Ажлын цаг ашиглалт, нийтийг хамарсан арга хэмжээнд оролцоо

2.2. Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг улирлын сүүлийн сарын сүүлийн 7 хоногт даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцүүлж байгууллагын дарга дүгнэнэ.

2.3. Үнэлгээ

- 85-100 оноо "Маш сайн" 40-50 хувь
- 70-85 оноо "Хэвийн" 10-40 хувь хүртэл
- 70 хүртэл "Хангалтгүй"

2.4. Дараах тохиолдолд мөнгөн урамшууллыг олгохгүй.

2.4.1. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 70 хүртэлх онооноос доош хувьтай дүгнэгдсэн бол

2.4.2. Сахилгын шийтгэл хүлээсэн эсхүл сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол